



ЦЕМЕНТ ШОХОЙ ТӨХК

ХӨТӨЛ

ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ

АГУУЛГА

01 ТАНИЛЦУУЛГА: “ЦЕМЕНТ ШОХОЙ” ТӨХК

10 КОМПАНИЙН БИЗНЕСИЙН ОНЦЛОГ

05 КОМПАНИЙН ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

11 ЭРГЭХ ЗУУХААР ШОХОЙ ҮЙЛДВЭРЛЭХ ТӨСӨЛ

01 ТАНИЛЦУУЛГА

АЛСЫН ХАРАА

Бид Монгол Улсын Барилгын материал үйлдвэрлэлийн төв байна.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Төр, хувийн хэвшил, ард түмний тэгш өмчлөлтэй, ил тод, цахим засаглалтай, нээлттэй хувьшаат компани болж, олон улсын стандартад нийцсэн бүтээгдэхүүнээр шударга өрсөлдөн, баялаг бүтээнэ.

ҮНЭТ ЗҮЙЛ

Манлайлал, хамтын хөгжил
Хариуцлага, ёс зүй
Найрсаг хүндэтгэлтэй
Шилдэг бүтээгдэхүүн
Шинэлэг үйлчилгээ

УРИА ҮГ

Хөгжил дэвшилд хөтөлнө

"ЦЕМЕНТ ШОХОЙ" ТӨХК

Хөтөлийн цемент, шохойн комбинатыг ББМУЯ-ны сайдын 1983 оны 127 дугаар тоот тушаалаар цемент, шохой, уулын олборлох үйлдвэр, засвар механикийн контор, дулааны станц гэсэн бүтэцтэйгээр анх үүсгэн байгуулжээ. 1984 онд шохойн үйлдвэрийн I зуухыг дөрвөн ээлжээр галлаж, үйл ажиллагаагаа эхлүүлж, анхны бүтээгдэхүүнээ "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-т нийлүүлсэн юм. Ингээд 1986 онд цементийн үйлдвэрийн технологийн II, II шугамыг Улсын комисс хүлээн авснаар цементийн үйлдвэрлэл эхэлсэн түүхтэй.



Байгуулагдсанаас хойш:

ЦЕМЕНТ

7.600.000 тонн

ЧУЛУУНЦАР

6.900.000 тонн

ШОХОЙ

1.600.000 тонн

УУЛ УУРХАЙ

15.873.021 м³

ДУЛААН

2.992.249 гкал

ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ



ЭРХЭМ БИЗНЕС ЭРХЛЭГЧ, ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ НАРАА!

Тэртээ 1983 онд Монгол Улсын уулын баяжуулах "Эрдэнэт үйлдвэр"-ийг шохойгоор хангах зорилгоор үүсгэн байгуулагдсан манай цемент, шохойн үйлдвэр 40 дэх жилийнхээ босгон дээр ирээд байна. Өнгөрсөн 40 жилийн хугацаанд бид 7.5 сая тонн цемент, 1.6 сая тонн шохой үйлдвэрлэн борлуулж, Монгол Улсынхаа барилгын салбарын бүтээн байгуулалтад чамгүй их хувь нэмэр оруулжээ.

"Цемент шохой" ТӨХК нь өдгөө дулааны охин компания оролцуулан 820 гаруй ажилтантайгаар цемент, шохой, чулуунцар, дулаан, уулын цул үйлдвэрлэл явуулж, ил тод, цахим засаглалыг хөгжүүлж, бие даасан үйл ажиллагааны тогтолцоог хэвшүүлж, бизнесийн алтан зарчмаар харилцан ашигтай хамтран ажиллах, үйлдвэрүүдийнхээ хүчин чадлыг нэмэгдүүлэх, шохойн үйлдвэрээ иж бүрнээр нь шинэчлэх зэрэг ажлыг ойрын зорилтоо болгон ажиллаж байна.


Бид ирэх он жилүүдэд Монгол Улсын Барилгын материал үйлдвэрлэлийн төв болох алсын хараатай байгаа билээ. Тиймээс үйл ажиллагаандаа олон улсын ISO стандартуудыг нэвтрүүлж, компанийн өрсөлдөх чадвар, үнэ цэнийг нэмэгдүүлэн, улмаар Хөрөнгийн зах зээлд бүртгэлтэй нээлттэй хувьцаат компани болох зорилгодоо хүрч, үндэсний тэргүүлэгч компани болно гэдэгт итгэл төгс байна.

Хүндэтгэсэн:

**"ЦЕМЕНТ ШОХОЙ" ТӨХК-ИЙН
Гүйцэтгэх захирал Л.Наранбаатар**

КОМПАНИЙН ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

“Цемент шохой” ТӨХК нь барилга, авто зам болон бусад салбар (баяжуулах үйлдвэр гэх мэт)-ыг түүхий эдээр ханган нийлүүлэх зорилгоор цемент болон шохойн бүтээгдэхүүний үйлдвэрлэл явуулж байна. Мөн охин компани болох “Хөтөл энэргији дулаан” ХХК нь аж ахуйн нэгж, байгууллага, айл өрхийг дулаанаар ханган ажиллаж байна.



УУЛЫН ҮЙЛДВЭР

Ордын нөөцийг анх 1980 онд Улсын ашигт малтмалын нөөцийн комиссоор батлуулж, 1989 онд төвийн геологийн экспедицээр ордын төв хэсэгт гүйцээх хайгуул, 1993-1997 онуудад Эрдэнэт УБҮ-ийн Геологи хайгуулын ангиар ашиглалтын хайгуулыг тус тус гүйцэтгүүлсэн. 2014 онд Хөтөл 1 болон Хөтөл 2 ордод геологи хайгуулын нэмэлт ажлуудыг гүйцэтгэж ордын нөөцийг МУ-н эрдэс баялгийн нөөцийн санд шинэчлэн бүртгүүлсэн. Хөтөл-1,2 шохойн чулууны ордуудад ил аргаар олборлолт явуулж, чулуунцар болон шохойн үйлдвэрийг шохойн чулуугаар тасралтгүй хангаж байна. Уулын үйлдвэр нь жилд дунджаар 50-60 мянган метр өрөмдлөг, тэсэлгээний ажил хийж 1,2 сая -1,5 сая м³ уулын цул ухаж, ачин, тээвэрлэх хүчин чадалтай.



ТӨМӨР ЗАМ



Ордын нөөцийг анх 1980 онд Улсын ашигт малтмалын нөөцийн комиссоор батлуулж, 1989 онд төвийн геологийн экспедицээр ордын төв хэсэгт гүйцээх хайгуул, 1993-1997 онуудад Эрдэнэт УБҮ-ийн Геологи хайгуулын ангиар ашиглалтын хайгуулыг тус тус гүйцэтгүүлсэн. 2014 онд Хөтөл 1 болон Хөтөл 2 ордод геологи хайгуулын нэмэлт ажлуудыг гүйцэтгэж ордын нөөцийг МУ-н эрдэс баялгийн нөөцийн санд шинэчлэн бүртгүүлсэн.

Хөтөл-1,2 шохойн чулууны ордуудад ил аргаар олборлолт явуулж, чулуунцар болон шохойн үйлдвэрийг шохойн чулуугаар тасралтгүй хангаж байна. Уулын үйлдвэр нь жилд дунджаар 50-60 мянган метр өрөмдлөг, тэсэлгээний ажил хийж 1,2 сая -1,5 сая м³ уулын цул ухаж, ачин, тээвэрлэх хүчин чадалтай.

"ХӨТӨЛ ЭНЕРЖИ ДУЛААН" ХХК

Дулааны станц нь 1984 онд цемент, шохойн үйлдвэр болон Хөтөл хотын айл өрх, албан байгууллагыг дулааны эрчим хүчээр хангах зорилгоор анх байгуулагдсан.

Өнөөдрийн байдлаар дулааны станц, дулааны шугам сүлжээ гэсэн хоёр үндсэн хэсэгт нийт 61 ажилтан дөрвөн ээлжээр ажиллаж байна. Тус компани жилд дунджаар 25 мянган тонн нүүрс, 2.8 сая кВт.ц цахилгаан эрчим хүч, 62 мянган метр куб ус хэрэглэж, 42 мянган Гкал дулааны эрчим хүч үйлдвэрлэдэг.



"ЦЕМЕНТ ШОХОЙ" ТЭХК

ЧУЛУУНЦАРЫН ҮЙЛДВЭР

Нойтон аргын технологиор баригдсан Чулуунцрын үйлдвэр нь 1985 оны аравдугаар сарын 10-нд эргэх I зууханд гол өгснөөр цементийн гол түүхий эд болох клинкер буюу хагас боловсруулсан бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж эхэлсэн түүхтэй.

Тус үйлдвэр нь 28 жилийн турш нойтон аргаар клинкер үйлдвэрлэж байгаад хуурай аргын технологитой, жилд 400 мянган тонн клинкер үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэрийг 2014 онд ашиглалтад оруулж, өнөөдрийг хүртэл тасралтгүй үйл ажиллагаагаа явуулж байна.



ШОХОЙН ҮЙЛДВЭР

Шохойн үйлдвэр нь 1980 онд хуучнаар ЗХУ-ын техник, эдийн засгийн тусlamжаар баригдаж, 1983 оны 12 дугаар сарын 11-нд I зууханд гал өгснөөр үйл ажиллагаагаа эхэлсэн түүхтэй.

Тус үйлдвэр нь “Хөтөл-1”, “Хөтөл-2” ордыг түшиглэн уулын баяжуулах “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын шохойн хэрэглээг хангах зорилгоор жилд 55,000 тонн шохой үйлдвэрлэх хүчин чадалтай, босоо 3 зуухтайгаар баригдаж ашиглалтад орсон. Шохойн үйлдвэр нь жилд 50,000-55,000 тонн шохойг дунджаар 75%-иас дээш идэвхжилтэй үйлдвэрлэж байна.

MNS347:2002 80%-иас доош
идэвхжилтэй



Барилгын хэрэглээний шохой

MNS347:2002 80%-иас дээш
идэвхжилтэй



Технологийн хэрэглээний шохой

ЦЕМЕНТИЙН ҮЙЛДВЭР

Анх 1984 онд I зуухаа галлаж эхэлснээр Цементийн үйлдвэрийн үйл ажиллагаа эхэлсэн түүхтэй. Цементийн үйлдвэр нь өвлөөс бусад улиралд тасралтгүй 4 ээлжээр 24 цагийн турш үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд өнөөдрийн байдлаар Монгол Улсын MNS974:2008 ангиллын стандартын дагуу PPC-32.5, OPC-42.5, PC-42.5, PC-52.5 маркийн цементийг үйлдвэрлэж, эх орныхоо бүтээн байгуулалтад бүтээгдэхүүнээ 40 жил тасралтгүй нийлүүлэн ажиллаж байна.

OPC-32.5



OPC 32.5-15% - М-20 зэрэглэлийн бетонд өргөн ашиглагдах ба даац авахааргүй их хэмжээний масс бетон шал, ханын цутгалт, авто зам, төмөр хийц бүхий тэгш гадаргуутай барилгад өргөн ашиглагдана.

OPC-42.5



OPC 42.5 - М-30 зэрэглэл нь өндөр чанартай бетон гаргаж авахад ашиглана. Цементийг барилгын өргөн хэрэглээний зориулалттай төмөр бетон, угсармал хийц хэсэг, гүүр далан, цутгамал эдлэл болон барилгын зориулалттай ашиглагдана.

OPC-52.5



OPC 52.5 маркийн өндөр ангиллын портланд цемент нь их ачаалал авах гүүр, олон холбоос бүхий барилга, байгууламж буюу цаг агаарын хүйтэн сэргүүн бүсэд баригдах барилга, байгууламжид өргөнөөр ашиглагдана.

ДОТООДЫН ЦЕМЕНТИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН БАГТААМЖ ЖИЛД 2 САЯ ТОНН БӨГӨӨД “ЦЕМЕНТ ШОХОЙ” ТӨХК НЬ 25%-ИЙГ НИЙЛҮҮЛДЭГ.

КОМПАНИЙН БИЗНЕСИЙН ОНЦЛОГ

Монгол Улсад орон сууц, авто зам, уул уурхайн томоохон төсөл, хөтөлбөрүүд жилээс жилд эрчимтэй хэрэгжиж, үүнийг даган барилгын материалын хамгийн гол бүтээгдэхүүн болох цемент, шохойн эрэлт, хэрэгцээ өсөн нэмэгдсээр байна. 2022 оны байдлаар шохойн зах зээлд технологийн шохой үйлдвэрлэж, бүтээгдэхүүнээ нийлүүлж буй хоёр компани байгаагийн нэг нь “Цемент шохой” ТӨХК бөгөөд “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын худэр баяжуулах үйлдвэрлэлд зайлшгүй шаардагдах технологийн шохойн хэрэгцээний 90%-ийг хангаж байна. Мөн авто болон вагон замын гүүр, бетон дэр, ус зайлцуулах хоолой зэрэг өндөр даац бүхий хийц өдлэлийн 52.5, барилгын салбарт өргөн хэрэглэгддэг 42.5, авто замын бүтээн байгуулалтад шаардлагатай 32.5 цементийг тус тус үйлдвэрлэж байна.



ЭРГЭХ ЗУУХААР ШОХОЙ ҮЙЛДВЭРЛЭХ ТӨСӨЛ

Эргэх зуухыг ХХ зууны эхэн үеэс шохойн үйлдвэрлэлд нэвтрүүлж эхэлсэн бөгөөд шинээр эхэлж буй шохойн үйлдвэрлэлийн дийлэнх төслүүд нь урьдчилсан халаагч бүхий эргэх зуухтай үйлдвэр суурилуулж байна. Эргэх зуухаар шохой үйлдвэрлэх нь доорх давуу талтай юм.

Үүнд:


- Үйлдвэрлэлийн хүчин чадал нэмэгдэх;
- Бүтээгдэхүүний нэр төрөл нэмэгдэх;
- Үйлдвэрлэсэн шохойн чанар сайжрах;
- Аливаа бат бөх өндөр болон чийг ихтэй карбонатлаг түүхий эд болон нарийн фракцын шохойн чулууг шатаах боломжтой;
- Түүхий эдэд (шохойн чулуу) тавигддаг агуулгын шаардлагууд буурах;
- Аюулгүй ажиллагааг хангасан үйл ажиллагаа явуулах нөхцөл үүсэх;
- Байгаль орчны сөрөг нөлөө багасаж, агаарын чанар сайжрах зэрэг ач холбогдолтой.



"Цемент шохой" ТӨХК нь жилд 100 мянган тонн шохой үйлдвэрлэх хүчин чадалтай, урьдчилсан халаагч бүхий эргэх зуухаар ажиллах технологид суурилсан Шохойн шинэ үйлдвэрийг ашиглалтад оруулахаар төлөвлөн ажиллаж байна. Энэ хүрээнд, Шохойн үйлдвэр шинээр барих төсөлд шаардлагатай судалгааны ажлуудыг хийж эхэллээ.

ЭРГЭХ ЗУУХААР ШОХОЙ ҮЙЛДВЭРЛЭХ ҮЙЛДВЭРИЙН ЕРӨНХИЙ КОНЦЕПЦ:

- Үйлдвэрийн хүчин чадал; - 100.0 мян.тн/жил
- Түүхий эд бэлтгэх технологи; - II шатны бутлалт (шохойн чулуу)
- I шатны нунтаглалт (нүүрс)
- Буталсан шохойн чулууны ширхэглэл; - 10-40 мм
- Үйлдвэрийн цаг ашиглалтын коэффициент; - 85%
- Шохой үйлдвэрлэх технологи;
- Хуурай аргын урьдчилан халаагчтай эргэх зууханд шатаах технологи;
- Жилийн дөрвөн улиралд тасралтгүй ажиллана;
- Хүн болон байгаль орчинд сөрөг нөлөө багатай, эргэх зуухнаас гарах утаа, тоног төхөөрөмжийн үйл ажиллагаанаас үүсэх тоосжилтийн асуудлыг шийдсэн;
- Бүхэл болон нунтаг шохой үйлдвэрлэнэ;
- Нунтаг шохойг силосоос хоёр тоннын биг-бэг уутанд савлаж хэрэглэгчид хүргэх;
- Үйлдвэрийг барьж байгуулах хугацаанд хуучин босоо зуух бүхий шохойн үйлдвэрийн үйл ажиллагаа хэвийн үргэлжлэх нөхцөлийг хангасан;
- Шохойн үйлдвэр нь хяналт, удирдлагын хувьд бүрэн автоматжсан байх шийдэлтэй.



БИД МОНГОЛ УЛСЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВ БАЙНА.



Хөгжилд хөтөлсөн 40 жил



📞 +976-70368151

✉️ info@khutulcement.mn

🌐 Цемент шохой ТӨХК